



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 271

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн
Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Монгол Улсын Их хурлын 2019 оны 02 дугаар сарын 1-ний өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5.11, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.9 дэх хэсгийг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга:	Э.Баттулга	Төрийн нарийн бичгийн дарга;
Гишүүд:	С.Энхтүвшин	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга;
	В.Жавзан	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;
	Б.Буяннэмэх	Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
	А.Энхбат	Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга;
	Б.Оюунсанаа	Ойн бодлого, зохицуулалтын газрын дарга;
	Ш.Цэрэндулам	Уур амьсгалын өөрчлөлтийн газрын дарга;
	С.Цогтгэрэл	Хуулийн хэлтсийн дарга;
Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга:	Л.Тунамал-Эрдэнэ	Төрийн захиргааны удирдлагын газрын Яамны нэгжийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн.

2022.04.13

2. “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн удирдлагаар ханган, Салбар зөвлөлийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга /Э.Баттулга/-д үүрэг болгосугай.

3. Салбар зөвлөлийг удирдлагаар хангаж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй байдалд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Ж.Эрдэнэбат)-нд даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 152 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2022 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛД

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Салбар зөвлөлийг байгуулах тухай асуудлыг хэлэлцэв. Үүнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүдээс дараах үүрэг чиглэлийг өгөв.

- 1.Төрийн албаны тухай хуулийг чанд сахиж, ёс зүйг эрхэмлэж ажиллахыг,
- 2.Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй 66 томилгоог хуульд нийцүүлэх талаар Төрийн албаны зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг шуурхай хангаж ажиллахыг,
- 3.Салбарын бодлогыг зөв ойлгон хэрэгжүүлж, зөв үр дүнд хүрэхийг,
- 4.Төрийн албанд хийгдэж байгаа шинэтгэлийн үйл хэрэгт манлайлж ажиллахыг,
- 5.2022 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн дотор Салбар зөвлөлийн үйл ажиллагааны явцын мэдээлэл, тайланг Төрийн албаны зөвлөлд ирүүлэхийг тус тус Салбар зөвлөлд чиглэл болгов.
- 6.Агентлагаас яаманд шилжин ажиллаж байгаа албан хаагчдад хүлээн зөвшөөрөгдөж ажиллахыг үүрэг болгов.



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА